

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 27-НЫ ӨДӨР
/МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТОВЬЁОГ**

№	Баримтын агуулга	Хуудас
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-4
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл	5-14
	1.Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг	5-7
	2.Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд эцсийн хэлэлцүүлэг	7-12
	3.Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд эцсийн хэлэлцүүлэг	12-13

Хураангуй тэмдэглэл

Хоёр.Зохιοгчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын шинжээч Д.Цолмон, Оюуны өмчийн газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга С.Ганзориг, мөн газрын Оюуны өмчийн хяналтын хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Аж үйлдвэрийн хэлтсийн дарга С.Урангэрэл, Монголын Оюуны өмч хамгаалах холбооны гүйцэтгэх захирал У.Тамир, Монголын Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Нэргүй нар цахимаар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Б.Галсанбат нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ц.Мөнх-Оргил нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Оюуны өмчийн тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т “Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны

хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай” гэж заасны дагуу санал хураалт явуулав.

С.Бямбацогт: 1.Төслийн гарчгийн “нэмэлт” гэсний дараа “, өөрчлөлт” гэж нэмж, төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх.

“2 дугаар зүйл. Оюуны өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “хянах” гэснийг “хянан баталгаажуулах, төлбөр төлөх, хуваарилахтай холбоотой гомдлыг урьдчилан шийдвэрлэх” гэж өөрчилсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 10

Татгалзсан 5

Бүгд 15

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн дугаарыг “3 дугаар зүйл” гэж, 3 дугаар зүйлийн дугаарыг “4 дүгээр зүйл” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 12

Татгалзсан 3

Бүгд 15

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

3.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 41.6, 41.7 дахь хэсэг болгох.

“41.6.Хараагүй, сонсголгүй, харааны, эсхүл сонсголын бэрхшээлтэй, хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлдэг төрийн болон эрх бүхий байгууллага, эсхүл дээрх байгууллагын албан тушаалтан нь бүтээлийг энэхүү хүмүүст хүртээмжтэй хэлбэрт хөрвүүлэн хуулбарлах, хил дамнуулан солилцох, хүлээн авах, түгээх, боловсролыг дэмжих зорилгоор мэдээллийн технологийн хэрэгслээр дамжуулан номын сангийн материалыг хүртээмжтэй болгож сургалтад ашиглах, бүтээлийг хичээлийн танхимд ашиглуулах, дэлгэж үзүүлэх, бүтээлийг зайны сургалтад зориулан хэсэгчлэн ашиглахыг зөвшөөрнө.

Тайлбар: Энэ хуульд заасан “хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбар” гэж хараагүй, сонсголгүй, харааны, эсхүл сонсголын бэрхшээлтэй, хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүнд бүтээлийг бусдын адил чөлөөтэй, саадгүй хүлээн авахад нь зориулан бүтээсэн сонгох боломжтой төрөл, эсхүл хэлбэрт хөрвүүлсэн хуулбарыг ойлгоно.”

41.7.Энэ хуулийн 41.1-д заасан зорилгоор бүтээлийн цахим хувийг олж авахаар эрх бүхий байгууллага хандсан бол тухайн цахим хувийг хадгалж байгаа байгууллага, хувь хүн саадгүй гаргаж өгөх үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Дэлгэрэнгүй тэмдэглэл

Дараагийн асуудалд оръё. Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найран төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя. За хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон эцсийн хуулбарын төслийг та бүхэнд тараасан байгаа. За хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцэлд бэлтгэсэн тухай ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг танилцуулна.

Ц.Мөнхцэцэг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2021 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хорооноос байгуулагдсан ажлын хэсэг Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, хуулийн нэр томъёо, найруулгын саналыг төсөлд тусган жигдэлж. Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэлээ.

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөвлөл нь зохиогчийн эрхийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр бүтээл, ашиглалтын тарифыг хянан баталгаажуулах, төлбөр төлөх хуваарилахтай холбоотой гомдлыг урьдчилан шийдвэрлэх чиг үүрэгтэй байх санал нь чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн тул Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу Оюуны өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт холбогдох өөрчлөлтийг тусгах саналыг гаргаж байна.

Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бэлтгэн та бүхэнд тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

С.Бямбацогт: За ажлын хэсгийн ахлагчид баярлалаа. Танилцуулга хийсэнд. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнууд түрүүн хэлсэн хэвээрээ өөрчлөгдөөгүй. За гишүүд нэмж ирцдээ орсон байна. Раднаасэд гишүүн, Пүрэвдорж гишүүн, Цогтбаатар гишүүд хуралдаанд хүрэлцэн ирсэн байна. За танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. За Энхбаяр гишүүн, Мөнх-Оргил гишүүн өөр байна уу? За асуулт тасаллаа. Энхбаяр гишүүн асуулт асууя.

Б.Энхбаяр: За гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгаж мэндчилье. Зохиогчийн эрхийн тухай хууль. Ер нь Оюуны өмчийн багц хуулиуд ингээд Байнгын хорооноос гараад эцэслэж батлагдах ийм үе шаттай явж байна. За Засгийн газраас болоод яг Зохиогчийн эрхийг дагасан Эрүүгийн хуулийн өөрчлөлт бол орж ирээгүй. За шинэчлэн батлагдах хэлэлцүүлгийг давж байгаа. Эцсийн хувилбарыг харахаар Эрүүгийн хуульд өөрчлөлт орох ийм шаардлага үүсэж байгааг бол бас би тэмдэглэж хэлэх гэж байна. Тэгээд Засгийн газар, холбогдох хүмүүс бас энийг анхааралдаа аваасай. Дараа нь нэмэлт өөрчлөлт, эрүүгийн хуулийн бас энэ зохиогчийн эрхтэй холбоотой өөрчлөлтийг бас боловсруулж яаралтай оруулж ирээсэй гэж хүсэх гэж байгаа юм. Тэгэхгүй бол энэ хууль маань бас цаашаа хэрэгжих хариуцлагын хэсэг нь байхгүй болж амилахгүй болох гээд байгаа юм.

Ялангуяа энэ эрүүгийн хуулийн арван 18.17 буюу Зохиогчийн эрхийг зөрчих гээд энэ гэмт хэрэг дээр ямар шинж биччихсэн бэ гэхээр зохиогчийн эрхийг зөрчиж бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн гээд байгаа юм. Заавал бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, за тэгээд их хэмжээний хохирол учирсан байх буюу 40-50 сая төгрөгийн заавал хохирол учирч байж гэмт хэрэг болох шинж биччихсэн. За бидний баталж байгаа энэ зохиогчийн эрх дээр харахаар энэ зохиогчийн, ялангуяа амины эрх, эд хөрөнгийн эрх гэж ялгаад. Амины эрх гэдэг бол өөрөө нөгөө хохирол учирсан байдлыг бол шаардахгүй хохирлыг тогтооход боломжгүй болох төвөгтэй ийм эрхийн харилцааг бол бид хуваалгаж ялгаж бичсэн. За тэгээд амины эрхлэлттэй холбоотой асуудлыг нэгэнт ингэж суурь хууль дээрээ өөрчилж байгаа учраас эрүүгийн дагасан эрүүгийн хууль дээрээ энийгээ бас яалгамаар байдал тогтоогдож байгаа. За миний анзаарч байгаагаар бол амины эрхийг зөрчсөн асуудал дээр хохирол шаардах бол боломжгүй юм байна.

Өөрөөр хэлбэл хэлбэрийн гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй байдлаар бичих шаардлага үүсэж байх шиг байна гэж харж байгаа.

За хоёрдугаарт энэ хохирол учирсан байна.

С.Бямбацогт: За Энхбаяр гишүүн нэмэлт нэг минут. Асуултаа гүйцээе.

Б.Энхбаяр: Хохирол учирсан байх шинж тогтооход төвөгтэй учраас, харин хууль бус орлого олсон байхыг үзэж болох юм аа гэж. Өөрөөр хэлбэл тухайн зохиогчийн нэр, юмыг ашиглаад тухайн гэм буруутай этгээд орлого олсон байх.

Тэрийг бичвэл илүү гэмт хэрэгтнийг яллах ийм боломж бүрдэх юм болов уу гэж ингэж харагдаад байгаа юм. За нөгөө талаараа хариуцлагын тухай гэхээр одоо бол 450 мянган төгрөгөөр торгохоос эхэлж байгаа. За гэтэл нөгөө Зохиогчийн эрхтэй холбоотой зөрчлийн хариуцлага маань болохоор 500 мянгаас эхлээд байгаа юм.

Тийм учраас эрүүгийн хариуцлага бол ямар нэгэн байдлаар зөрчлийнхөө шийтгэлээс гэмт хэрэг учраас ял нь бол илүү чанга хатуурч явах ёстой гэдэг утгаар, бас энийг бас Засгийн газар, дараа нь энэ хууль маань батлагдсаны дараа эрүүгийн хуулийн өөрчлөлтийг яаралтай оруулж ирэхдээ энэ асуудлуудыг бас анхаарч хуулийн төслөө оруулж ирээсэй гэдэг утгаар би протоколд тэмдэглүүлж.../минут дуусав./

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч хариулах уу? Ажлын хэсгээс хариулах уу? Хууль зүй, дотоод яамныхан бас ажлын хэсэгт байгаа. Мөнхцэцэг гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Энхбаяр гишүүний энэ үндэслэлтэй бол санал нэг байна. Зохиогчийн эрхийн тухай хуулийн зөрчсөн этгээдүүдэд бол зөрчлийн тухай хууль, мөн эрүүгийн тухай хуулиараа хариуцлага хүлээлгэж байна. Зөрчлийн тухай хуулийн 8.3 дээр тухайн одоо зохиогчийн эрхийг зөрчсөн, бүтээл ашигласан тохиолдолд тухайн учирсан хохирлыг хууль бусаар олсон хөрөнгө орлогыг хурааж авч учирсан хохирлыг нөхөн төлбөрийг нь гаргуулах за тэгээд мөнгөн дүнгээр энэ маань 500 мянган төгрөгөөс эхэлж байгаа юм. За тэгээд яах аргагүй эрүүгийн тухай хуульд болохоороо энэ зөрчлийн тухай хуулиас илүү тийм зөөлөн заалттай байгаад байгаа учраас яах аргагүй эрүүгийн тухай хуульд тэр амины эрх болон бусад эрхийг зөрчсөн тохиолдолд үзүүлэх хариуцлагыг чангатгах нь зүйтэй гэдэг дээр бол санал нэг байна. За тэгэхээр, энэ дээр бол Засгийн газраас эрүүгийн тухай хуулийн төслийг өөрчлөн найруулах төсөл өргөн барихдаа оруулах нь зүйтэй гэж бол бодож байна. Ажлын хэсгээс.

С.Бямбацогт: За хариулт хангалттай байх гэж бодож байна. Манай хууль зүй, дотоод хэргийн яамныхан бас анхааралдаа аваарай. Саяын гишүүдийн ярьж байгаа асуудлыг за ингээд Мөнх-Оргил гишүүн асуулт асууя.

Ц.Мөнх-Оргил: Сайн байцгаана уу? Байнгын хорооны гишүүд, ажлын хэсгийн л энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Зохиогчийн эрхийн хуульд хараагүй, сонсголгүй, харааны эсгүй, сонсголын бэрхшээлтэй, хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүний хэрэгцээнд зориулан ашиглах 41 дүгээр зүйл орж байна. Ер нь бол их том дэвшилт гарч байгаа юм. Гэхдээ энэ 41.1-д заасан зөвшөөрнө гэдэг заалтыг жоохон чангатгаж, энэ бүтээлийг ашиглах эрхийг заавал гаргаж өгч байна, ийм хүмүүст гаргаж өгч байна гэсэн үүрэг болгож өгөх шаардлага байна гэж манай хөгжлийн бэрхшээлтэй иргэд тухайн бол хараагүйчүүдийн холбооноос санал ирээд байгаа юм.

Тэгээд энэ нөгөө саналын өчигдөр Байнгын хороо, ажлын хэсэг дээр хэлэлцээд 41.1, 41.6-д бол ер нь санаа нь орчихсон юм байна гэдгээр аваагүй юм байна аа. Тэгээд би өнөөдөр энэ санал энэ асуудлаар дахиж санал хурааж өгөөч ээ. Дэгийн хуулиар 42.2.3-аар энэ заалтыг ашиглаад 41.6 бол бид нар хөндчихсөн байгаа шүү дээ. Анхны хэлэлцүүлгээр. Тэгэхлээр 41.6-г 2/3-аар дахиж найруулаад, энэ 41.6-ийн хойд талд нь ийм өгүүлбэр нэмэх саналтай байна. 41.6-г одоо байгаагаар нь харуулж биччихсэн байгаа нь дээр нь нэг өгүүлбэр. Энэ хуулийн 41.1-д заасан зорилгоор бүтээлийн цахим хувийг олж авахаар эрх бүхий байгууллага хандсан бол тухайн цахим хувийг хадгалж байгаа байгууллага, хувь хүн саадгүй гаргаж өгөх үүрэгтэй гэж үүрэгжүүлж өгмөөр байна. Бид нар бол энэ хүмүүсийн зовлонг мэдэхгүй, гэхдээ энэ хүмүүсийн өөрсдийнх нь ярьж байгаагаар бол зүгээр зөвшөөрнө, болно гээд хэлчих нь бол хангалтгүй юм.

Яг амьдрал дээр энэ бүтээлүүдээ авах гэхлээр тэр нөгөө бүтээлийг нь хадгалж байгаа байгууллагууд цахимаар нь гаргаж өгдөггүй, зохиогчийн эрх нь бол хадгалагдчихсан.../минут дуусав/

С.Бямбацогт: Мөнх-Оргил гишүүний чинь сунгая гэсэн үү, гайгүй юу? За нэг минут гэж байна, нэмэлт 1 минут байна.

Ц.Мөнх-Оргил: Тэгэхлээр миний хэлэх гээд байгаа санаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагуудын хэлээд байгаа санаа бол энэ хуулиар зохиогчийн эрхийн асуудлууд байхгүй болчхож байгаа юм. 41.1-ээр зохиогчийн эрх талаасаа, тэр бүтээлийг цахим хэлбэрээр хадгалж байгаа байгууллагууд нь гаргаж өгөхгүй байх юм бол тэд зохицуулалтгүй үлдчихээд байна аа, тийм учраас энийг энэ үүрэгжүүлж өгөөч ээ гэсэн хүсэлт тавиад байгаа юм .

Тийм учраас би Байнгын хорооны даргаас миний энэ саналаар санал хурааж өгөөч ээ. Дэгийн хуулийн 42.2.3-ыг иш үндэс болгож байгаа. Байнгын хорооны гишүүдийн энэ саналыг дэмжиж өгөөч ээ гэж хүсэж байгаа юм. Бид нар хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ болж өгвөл дэмжмээр байгаа. За баярлалаа.

С.Бямбацогт: За санал хураалт явуулах бол боломжтой дэгийн хуулиараа. Манай ажлын хэсгээс бас энэ тал дээр ямар нэг тайлбар байна уу? Мөнхцэцэг гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ Монголын хараагүйчүүдийн нийгэмлэгийн ирүүлсэн энэ саналыг бол өчигдөр ажлын хэсэг дээр бид нар ярилцсан юм. За тэгээд ерөнхийдөө энэ 41 дүгээр бүлэг маань бүхэлдээ хараагүй болон сонсголгүй, харааны эсвэл сонсголын бэрхшээлтэй иргэдэд тухайн бүтээлийг хүртээмжтэй хэлбэрээр хүргүүлэх тухай ийм бүлэг байгаа.

За тэгээд энэ бүлэг дээр эрх бүхий байгууллага буюу энэ тухайн энэ хүнийг бас л мэргэшсэн сургалт, номын сан мэдээллээр хангах чиглэлээр дагнасан үйл ажиллагаа эрхэлдэг Төрийн болон төрийн бус байгууллагууд энэ хараагүй, сонсголын бэрхшээлтэй иргэдэд энэ бүтээлийг хүртээмжтэй хэлбэрээр хуулбар гаргаж өгөх эрхтэй гэж оруулсан учраас за энийг бол заавал үүрэгжүүлээд явах шаардлагагүй гэж? Манай ажлын хэсгийн олонхын гишүүд үзсэн. За тэгэхдээ Байнгын хороон дээр бид нар санал хураалт явуулаад 2/3-оор дэмжвэл хуулийн төсөлд оруулах бүрэн боломжтой гэж үзэж байна.

С.Бямбацогт: Ажлын хэсгээс нэмэлт хариулт байгаа юу? Яамнаас, Оюуны өмчийн газраас энэ уул нь боломжтой байна шүү. Эрх ашиг нь хөндөгдөж байгаа иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр л үүрэгжүүлсэн санал орох гээд байгаа юм байна шүү дээ? Тийм ээ, энд яагаад болохгүй гэж үзсэн юм бол. Хэрвээ тайлбар хариулт байхгүй бол Мөнх-Оргил гишүүн зарчмын зөрүүтэй саналаа бэлдээд өгчих үү? За саналууд байгаа юу? Тайлбар байна уу? За алга байна. Өөр асуулт асуух гишүүд байхгүй байгаа. Тийм ээ, тийм. За асуулт асууж хариулт авч дууслаа.

Ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулъя. Дараа нь Мөнх-Оргил гишүүн саналаа бэлдэж байгаарай.

Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Оюуны өмчийн тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгийн

зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хураалгах санал.

Нэг төслийн гарчгийн “нэмэлт” гэсний дараа “өөрчлөлт” гэж нэмж төсөл доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх.

2 дугаар зүйл. Оюуны өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “хянах” гэснийг “хянан баталгаажуулах, төлбөр төлөх, хуваарилахтай холбоотой гомдлыг урьдчилан шийдвэрлэх” гэж өөрчилсүгэй. Санал гаргасан ажлын хэсэг. 2/3 билүү энэ чинь. За гишүүд анхааралтай байгаарай. Гуравны хоёроор энэ санал дэмжигдэх ёстой. За эхлээд төслийн бүртгэлийн санал хураалт. Минийх ордоггүй. Минийх болохгүй байна шүү. Одоо болж байна. Гишүүд ирцдээ анхаарна уу? Алтанхуяг гишүүн, Дэлгэрсайхан гишүүн, Мөнхбаатар гишүүн, Нямбаатар гишүүн, Пүрэвдорж гишүүн, Цогтбаатар гишүүд. За одоо гишүүд ирцдээ бүгд орсон уу? За санал хураалт явуулах уу?

Нэг төслийн гарчгийн “нэмэлт” гэсний дараа “өөрчлөлт” гэж нэмж төсөл доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх.

2 дугаар зүйл. Оюуны өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “хянах” гэснийг “хянан баталгаажуулах, төлбөр төлөх, хуваарилахтай холбоотой гомдлыг урьдчилан шийдвэрлэх” гэж өөрчилсүгэй. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 2/3-оор дэмжигдэх ёстой. За санал хураалтад 15 гишүүн оролцогч 10 гишүүн буюу 66.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Нямбаатар сайд хууль оруулж байгаа. Засгийн газар, яамныхан хэлээрэй.

Дараагийн санал хураалт, Төслийн 2 дугаар зүйлийн дугаарыг “3 дугаар зүйл” гэж, 3 дугаар зүйлийн дугаарыг “4 дүгээр зүйл” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 15 гишүүн орсноос 12 гишүүн буюу 80.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

За одоо гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна. Мөнх-Оргил гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал.

Төслийн 41 дүгээр зүйлийн 41.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 41.6, 41.7 дахь хэсэг болгох.

“41.6.Хараагүй, сонсголгүй, харааны, эсхүл сонсголын бэрхшээлтэй, хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлдэг төрийн болон эрх бүхий байгууллага, эсхүл дээрх байгууллагын албан тушаалтан нь бүтээлийг энэхүү хүмүүст хүртээмжтэй хэлбэрт хөрвүүлэн хуулбарлах, хил дамнуулан солилцох, хүлээн авах, түгээх, боловсролыг дэмжих зорилгоор мэдээллийн технологийн хэрэгслээр дамжуулан номын сангийн материалыг хүртээмжтэй болгож сургалтад ашиглах, бүтээлийг хичээлийн танхимд ашиглуулах, дэлгэж үзүүлэх, бүтээлийг зайны сургалтад зориулан хэсэгчлэн ашиглахыг зөвшөөрнө.

Тайлбар: Энэ хуульд заасан “хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбар” гэж хараагүй, сонсголгүй, харааны, эсхүл сонсголын бэрхшээлтэй, хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүнд бүтээлийг бусдын адил чөлөөтэй, саадгүй хүлээн авахад

нь зориулан бүтээсэн сонгох боломжтой төрөл, эсхүл хэлбэрт хөрвүүлсэн хуулбарыг ойлгоно.”

41.7.Энэ хуулийн 41.1-д заасан зорилгоор бүтээлийн цахим хувийг олж авахаар эрх бүхий байгууллага хандсан бол тухайн цахим хувийг хадгалж байгаа байгууллага, хувь хүн саадгүй гаргаж өгөх үүрэгтэй.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил. 41.6 бол тайлбартай шүү гэдгийг бас хэлье ээ. За ингээд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 2/3-аар бас дэмжигдэнэ. Санал хураалт. Санал хураалтад 15 гишүүн оролцож 11 гишүүн буюу 73.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. За санал хураалтууд явуулж дууслаа.

Гишүүд ажлын хэсгийн болон гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар. Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг явуулж дууслаа. Хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч танилцуулах уу. За Мөнхцэцэг гишүүн танилцуулна.